

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд Монгол улсад олон улсын иргэний эрх зүйн тухай тусгай хуулийг батлан гаргаж, зөрчилдөөний асуудлыг зохицуулж өгөх цаг нэгэнт болжээ. Гадаад харилцаа өргөжин хөгжиж буй өнөө үед ийм хуулийг гаргахгүй бол нэг өдөр л манай шүүх мухардалд орох болно. Иргэдийнхээ эрх ашгийг хилийн чанадад хамгаалахад зөвхөн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ хангалтгүй.

АЛТАН АРГАМЖ

197

IV. ДУРСАМЖ

МОНГОЛД АЖИЛЛАХ ТОМИЛОЛТОО ДУУСГААД...

1998-1999 онд БНСУ-аас Монгол
улсад сууж байсан Элчин сайд
Хван Гил Синий "Diplomacy"
сэтгүүлд нийтлүүлсэн дурсамж.

1999 оны 10 дугаар сар

Монгол орноос явахынхаа өмнө өнгөрсөн хоёр жил хагасын хугацаанд хийсэн ажлаа эргэж харахад төрийн албан хаагчийн хувьд идэвхитэй ажиллаж, амьдарч дээ гэсэн сэтгэгдэл төрж байна. Монголд ажиллана гэж зүүдлээ ч үгүй явсан би, томилолтын албаа дуусгаад Монгол явах болсноо сонсоод хүнд зурсан зураг гэж байдаг бололтой гэж бодсон билээ.

Би Монголд ирэхийнхээ өмнө Кувейтээс гадна гол төлөв Европын орнуудад Германд гурван удаа, Унгар, Шинэ Зеландад ажиллаж байв. Шинэ Зеланд хэдийгээр Номхон далайд орших боловч Европоос цагаачлан очсон хүмүүс их байдаг учир Европтой адилтган үздэг. Миний дипломатчийн ажил амьдралын нэг хэсэг хугацаа Монголтой холбогдох юм гэж тэр үед санасангүй явжээ. Улаанбаатар дэлхийн хамгийн хүйтэн хот өдөр, шөнө, өвөл, зуны цаг агаар нь эрс тэс учир гадны хүмүүс эрүүл мэнддээ онцгой анхаарах хэрэгтэй юм. Тиймээс ч энд суугаа хөгжингүй орны дипломатууд жилдээ 2-3 сар нутагтаа очиж амардаг.

Монголын цаг агаарт харьцангуй амархан дасдаг гэх Солонгосчууд ч 3-4 жил болоход өөрөө ч мэдэлгүй бие нь муудаж, урьд өмнө байгаагүй харшиллын өвчтэй болж шаналах хүмүүс цөөнгүй байдаг.

Би Монголд томилогдсоноо надад ногдсон хувь тавилан хэмээн бодож амьдралдаа идэвхитэй, зориг тэвчээртэй байж ажиллахаар шийдсэн. Бэрхшээлийн өмнө өвдөг сөхөрч унжтар байх юм бол улам дордоно гэдгийг ажил амьдралынхаа туршлагаас мэдэж байв.

"Довтолгоон бол хамгийн сайн хамгаалалт" гэсэн үг байдаг даа.

Хван Гил Син

"Монгол ажиглах томилолтоо дуусгавал..."

Юуны өмнө суугаа орныхоо нөхцөл, байдалд дасч морь унаж, дайлага цайллагад оролцохдоо хонины мах, айраг зэрэг уламжлалт хоол, ундаанаас өөрийнхөө хэмжээнд тохируулан хэрэглэж сурсан юм.

Би Монголд ийнхүү идэвхитэй ажиллаж амьдарч байснаа одоо эргэн санахад энэ томилогтыг би өөрөө сонгосон юм шиг санагдана. Намайг Монголд ирэхийн өмнө дээд газраас санал болгосон гурван сонголтоос амьдралын нөхцөл хамгийн хүнд гэх Монголыг сонгосон хэрэг.

Адуу бол монголчуудын хамгийн эрхэмлэн үздэг амьтан бөгөөд монголчуудтай уулзахдаа морины тухай яриа өдвөл хэн ч гэсэн дуртай хүлээж авдаг тул Монголд амьдарч буй хүн морины тухай хууч яриа олныг сонсож, тогтоон авч ашиглаж байх нь зүйтэй юм гэж боддог.

Би хэзээнээс моринд дуртай, морь унах юмсан гэж мөрөөддөг байв. Европ, Шинэ Зеландид ажиллаж байхдаа морь унаж сурахыг хүсэж байсан ч хэрэгжүүлэх боломж гараагүй. Монгол бол адууны эх орон билээ. Адуу нь хүн амаасаа олон. Хөдөө орон нутагт гол тээврийн хэрэгсэл болдог тул хаана ч очсон морь унах боломж их. Иймд энэ сайхан боломжийг алдахгүйг хичээж байв. 1997 оны 4 дүгээр сард Монголд томилогдон очоод 5 дугаар сараас эхлэн морь унаж эхэлсэн. Эхлээд унасан морио хүнээр хөтлүүлж байсан бол 2-3 сарын дараа ганцаараа давхиулдаг болов.

Морь унана гэдэг осолтой ч нас ахисан үедээ хожуу ч гэсэн морь унаж монголын амьдралд дасаж байгаадаа урамшин ийм боломж олгосонд бурханд талархаж байв.

Монголын зун морь унахгүй ч гэсэн цаг алсаар сайхан учир сайхан амарч тухалж болох бөгөөд нутгаас ирэх зочин төлөөлөгчид тасрахгүй тул зав чөлөө муутай байв.

Урт хүйтэн өвлийн улиралд эрүүл мэндээ хамгаалах явдал чухал байв. Монголд хавар, намрын улирал байх авч үнэндээ өвөл, зуны хоёр улиралтай. Жилээс жилд халуун, хүйтний хэм бага зэрэг өөрчлөгдөж байгаа хэдий ч 10 сараас дараа оны 4 сар хүртэл өвөл, 5 сараас 9 сар хүртэл зун гэж үзэж болох юм.

12 сараас 2 сар хүртэл үргэлжлэх дун өвөлд шөнөдөө 40 хэм хүрч хүйтрэх бөгөөд өдөрт -25-30 хэм, нартай өдөр -15 хэм хүрнэ. Ийм нөхцөлд гадагш гарч ажиллахад бэрх болно. -15 хэмтэй

байхад зөвхөн нүд, хамраа ил гарган дулаан хувцаслаад мөсөн дээр гулгаж болох авч цантаад удаан байхын аргагүй. Ийм нөхцөлд байшин дотор одон бөмбөг тоглох нь хамгийн тохиромжтой. Урт өвөл нь цана чаргаар гулгаж болох юм гэж бодох авч орчин үеийн тоног төхөөрөмжтэй газар байхгүй, хэт хүйтэн учир байгуулах ч боломжгүй юм шиг байна лээ.

Одон бөмбөг нь байшин дотор бага талбайд тоглох боломжтой, тэгээд ч хөдөлгөөн ихтэй тул Монгол оронд өвлийн улирлын хамгийн тохиромжтой спорт байж болох мэт санагдана. Манай ЭСЯ одон бөмбөгийн бүрэн хэрэгсэлтэй бөгөөд ажилтнууд ч муугүй тоглоно.

Монголд оршин суугаа солонгосчуудын дунд одон бөмбөгийн спорт хамгийн их дэлгэрсэн. 1988 оны Сөүлийн Олимпын эмэгтэй хос тоглолтын алтан медальт тамирчин Ян Ен Жа болон эрэгтэйчүүдийн шигшээ багийн тамирчин Пак Жи Хен нар Монголд ажилладаг юм. Тэд шашны шугамаар Монголд ирж одон бөмбөгийн клуб байгуулан монголын одон бөмбөгийн тамирчдыг дасгалжуулан бэлтгэж байна. Манай солонгосчууд ч гэсэн тэр клуб очиж дээд зэрэглэлийн дасгалжуулагчаар багшлуулж байна. Нутагтаа бол хэнээс ч дордохгүй ажиллаж амьдрах боломжтой тэд нар амьдралын хүнд нөхцөлтэй Монголд ирж монголчуудтай зовлон жаргалаа хуваалцаж байгаа нь тэр. Тэдний хүчин зүтгэл чармайлтын үр дүнд ойрын ирээдүйд Монголын одон бөмбөгчид олон улсын тавцанд гарч ирнэ гэдэгт итгэж байна.

Би Монголд ажиллах хугацаандаа биеийн эрүүл мэндээ төдийлөн анхаарч байгаагүй боловч оюун санааны хувьд эрүүл байхын үндэс болсон итгэл үнэмшилтэй болсондоо олзуурхаж байдаг юм. Урьд өмнө нь шашин шүтэх санаа байсан боловч боломж олдохгүй байсаар хэрэгжүүлж чадахгүй байв.

Тэгээд Монголд томилогдон очоод Улаанбаатарт цорын ганц байдаг Солонгос иргэдийн христосын сүмд очиход нутаг нэгтнүүдтэйгээ танилцах боломж олдож тэдэнтэй уулзан ярилцаж санаа бодлоо хуваалцдаг нь ажил төрлөө явуулахад тустай байв. Тиймээс бүтэн сайн өдөр болгон сүмд очих нь миний ажлын нэг хэсэг болсон билээ. Ялангуяа өвлийн хүйтэнд гадуур явах боломжгүй гэр, контороос гардаггүй над шиг хүнд сүмд очих нь салхинд гарч толгойгоо сэргээх шиг болдог байв. Ийнхүү 2 жил гаруй хугацаа өнгөрч өөрөө ч мэдэлгүй шашны зан үйлийг

хүндэтгэн дагадаг болсон юм.

Сүмийн лам хуврагууд, сүсэгтнүүд ихэнхи нь тавлаг аятай нөхцөлд тайван амгалан амьдарч байгаа атлаа ядарч зүдэрсэн хүмүүст туслах, тэдний төлөө гэсэн сэтгэлээр хандаж сэтгэл оюунаа ариутгаж буйг хараад тэдний цаана нүдэнд үл үзэгдэх далдын хүч байгааг мэдрэх шиг болдог байв.

Нэр төртэй амьдрах хүсэл эрмэлзэл хүн бүрт байдагчлан төрийн албан хаагч бидний хувьд өөртөө ногдсон үүргээ сайн биелүүлж зорьсон хэрэг маань үр дүнд хүрвэл түүгээрээ бахархаж явдаг билээ.

Дипломатуудын хувьд нэр төртэй үйлс бүтээх боломж зам олон боловч суугаа оронтойгоо харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулсан гэсэн үнэлэлт авах нь хамгийн баяртай мөч байдаг.

Би Монголд томилогдон очоод Монголын удирдах албаны хүмүүст бараалхан ажил төрөлтэйгээ танилцах явцад томилогдлынхоо хугацаанд Солонгос-Монголын харилцааг хөгжүүлэхэд хэрэгжүүлбэл зохих хоёр чухал зүйл байна гэдгийг ойлгосон. Нэгдүгээрт, Бид боломжийнхоо хирээр Монголчуудад туслах хэрэгтэй юм байна. Хоёрдугаарт, Өөрийн орны удирдлагад Монгол улстай харилцахын ач холбогдлыг ойлгуулж, Монголын талаархи сонирхлыг нь төрүүлэх явдал байв. Тэгээд намайг томилогдохоос өмнө хоёр орны засгийн газрын хооронд яригдаж байсан Монголын үйлдвэрийн даллага хийгчдийг Солонгост ажиллуулах асуудлыг шийдвэрлэхээр хөөцөлдөж үр дүнд хүргэсэн. Монголд ирсэн Солонгосчуудад "Монголд жаахан ч гэсэн туслахад том үр дүнд хүрч болох улс" гэдгийг тайлбарлан Монголд тусламж дэмжлэг үзүүлэхэд анхаарч ажилласан.

Манай улсаас олон улсын хамтын нийгэмлэг /ЖОЙКА/-ийн шугамаар хэрэгжүүлж буй буцаалтгүй тусламж, Гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны фонд /ЕДСГ/-ээс үзүүлж буй урт хугацааны хөнгөлөлттэй зээлээс гадна Засгийн газрын бус байгууллага, хувийн хэвшил, хувь хүмүүсээс үзүүлж буй тусламж ч багагүй хувийг эзэлж байгаа билээ.

Хоёр орны харилцааг хөгжүүлэхэд Засгийн газраас гадна засгийн газрын бус олон нийтийн болон хувийн хэвшлийн зүгээс ч үзүүлэх тусламж, дэмжлэгийг нэмэгдүүлэх боломжийг ашиглах нь

зүйтэй юм гэж боддог байв. Тиймээс ч Монголын Засгийн газраас 1998-2004 онд хэрэгжүүлж буй Ногоон хувьсгалын хөдөлгөөнийг хувийн хэвшлийн шугамаар дэмжихэд анхаарч ажилласан билээ. Монголд өрнүүлж буй Ногоон хувьсгалын хөдөлгөөн нь гол төлөв мах иддэг монголчуудын хоолны ширээн дээр шинэ ногоо тавих юм бол эрүүл мэндэд нь тустай, цаашлаад ард түмний амьдралыг нь дээшлүүлэхэд чиглэгдсэн бүх ард түмний хөдөлгөөн юм.

Энэ хөдөлгөөнийг дэмжиж Монголд солонгосын кимчи/дарсан байцаа/-г нэвтрүүлэх аваас хэн хэнд нь ашигтай юм гэж бодсон. Тэгээд ч тэнд ажиллаж байсан Солонгосын мэргэжилтнээр Монголчуудад төрөл бүрийн хүнсний ногоо тарьж ургуулах технологийг заалгаж, Монголын төв телевизтэй хамтран солонгос хоол, кимчи хийх аргын тухай цуврал хичээл зааж нэвтрүүлэг явуулж, зөвхөн ногоогоор хийсэн Солонгос хоолны үзэсгэлэн зохион байгуулж Ерөнхийлөгч Н.Багабанди өөрөө биечлэн оролцож байв. Одоо Улаанбаатарчууд Солонгос кимчиний амтанд ороод байна.

Хүн солилцоо бол тухайн орнуудын харилцааны нэг гол үзүүлэлт байдаг. Улс төр, эдийн засаг, соёлын болон аль ч салбарт сайн харилцаатай байв гэвэл юуны өмнө хүмүүс өөр хоорондоо уулзаж харилцах хэрэгтэй юм. Улс орны харилцаа сайн биш байх юм бол жуулчдын тоо ч аяндаа цөөрөх нь дамжиггүй.

Би Монголд томилогдож очоод Монголчууд хоёр орны хооронд өндөр албан тушаалын хүмүүс харилцан айлчлах явдал тэнцвэртэй биш байгаад монголчуудын сэтгэл дундуур байдгийг олон удаа сонссон. Энэ нь Монголын талаас Ерөнхийлөгч, УИХ-ын дарга зэрэг төр засгийн удирдах албаны хүмүүс БНСУ-д айлчилсан байхад Солонгосоос тэдний зиндааны хүмүүс Монголд хариу айлчлал хийгээгүйг хэлж буй хэрэг.

Өөрөөр хэлбэл өөртөө бүрэн итгэлтэй байдаг Чингис хааны удмын монголчууд Солонгосын үл тоомсорлосон байдалд сэтгэл дундуур байгаа нь мэдрэгдэж байв. Тиймээс ч Монголтой харилцахад эдийн засгийн хамтын ажиллагаа чухал ч гэсэн өөрчлөлт шинэчлэлтийн замд өөрийн гэсэн байр суурьтай Монголд манай-хаас дээд хэмжээний төлөөлөгчид айлчлах нь чухал юм гэдгийг ойлгож, түүнээ хэрэгжүүлэхийн төлөө хөөцөлдөн ажилласан.

Дипломат харилцаа тогтоосноос хойш манайхаас Ерөнхийлөгч, Ерөнхий сайд бүү хэл, 1992 онд Гадаад хэргийн сайд

айлчилснаас хойш хэн ч очсонгүй 6 жил болсон байв.

Монгол улс Зүүн хойт Азийн бүс нутагт хамрагддаг газар нутгийн хувьд ч ойр төдийгүй манай улстай гарал, үүсэл, хэл соёл түүхийн хувьд ч гүнзгий холбоотойг бодолцон орны хувьд онцгой сайн харилцаатай байх явдал чухал болохыг Гадаад хэргийнхээ яамны удирдлагад ойлгуулах хэрэгтэй байв. Тэгээд ч юуны өмнө Гадаад хэргийн сайдыг Монголд айлчлуулахаар хөөцөлдөж байх үед 1998 онд Элчин сайд нарын зөвлөлгөөн Сөүлд болсон юм. Энэ завшаанд сайдтайгаа уулзаж монголд айлчуулах гэсэн боловч сайдын цаг заваас шалтгаалан уулзаж чадалгүй байсаар тэрээр зөвлөлгөөний дараа элчин сайд нартэй салах уулзалт хийж гар барих үед нь Монголд заавал айлчлахыг хүссэн билээ.

Тэгэхэд сайд маань "Тийм үү. Болох л юм" гэсэн нааштай хариу өгсөнийг би тухайн үедээ зүгээр ам дагуулж л байна даа гэж бодлоод өнгөрсөн билээ. Буцаж очоод байж байтал 2 сарын дараа гэнэт төвөөс сайдыг Монголд айлчлуулах тухай заавар ирэх нь тэр. Сөүлд түр уулзахдаа миний хэлсэн санал үр дүнд хүрсэн үү, эсвэл сайд өөрөө Монголын талаар сонирхдог хүн болоод ингэж шийдвэрлэв үү гэж гайхаж байв. Ямар ч гэсэн 1992 оны 4 сард Ли Сан Ок сайдын айлчилснаас хойш 6 жилийн дараа ГХХ-ны сайд Пак Жөн Су 1998 оны 7 сард Монголд айлчилсан билээ.

Гадаад Харилцаа, Худалдааны сайдын Монголд хийсэн айлчлал нь Монголын төр, засгийн удирдах хүмүүсээс хоёр орны хооронд өндөр албаны хүмүүс харилцан зорчих явдал тэнцвэртэй бус байгаад сэтгэл дундуур байдгийг арилгахад тус болсон төдийгүй Ерөнхийлөгчийн айлчлалыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чухал түлхэц болсон юм.

Би Элчин сайдаар ажиллах хугацаандаа Ерөнхийлөгч Ким Дэ Жүн 1999 оны 5 дугаар сард Монголд айлчлах болсныг хамгийн аз завшаантай, нэр төртэй үйл явдал гэж үздэг.

Ерөнхийлөгч Ким Дэ Жүнг сонгуулийн нь хугацаанд Монголд айлчлуулах боломж гарах байх гэж бодож байв. Учир нь, Ерөнхийлөгч гадаад бодлогыг сайтар мэддэг хүний хувьд Солонгос-Монголын хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагыг ойлгодог, нөгөө талаар, Ерөнхийлөгч нэр дэвшихдээ болон дараа нь Зүүн хойт Азийн 6 талын яриа хэлэлцээтэй холбогдуулан шаардлагатай бол Монголыг ч оролцуулж болох юм хэмээн тэмдэглэж байсан

билээ. Хамгийн гол нь цаг хугацааны асуудал байв.

Манай орны гадаад харилцааны нөхцөл байдлаас Ерөнхийлөгч зөвхөн Монголд тусдаа айлчилна гэдэг бүтэл муутай, өөр хөрш зэргэлдээ оронд айлчлахад нь хамтруулна гэхэд Хятад, Оросод айлчлахтай холбоотой асуудал байв. Ерөнхийлөгчийг АНУ, Японд айлчилсны дараа Хятад, Орос айлчлах бэлтгэл хийж байх үед Монголд айлчлуулах саналаа төвдөө илгээсэн билээ. Ерөнхийлөгч Ким Дэ Жүний Монголд хийх төрийн айлчлал нь тэнд суугаа Элчин сайдын саналаар тийм амархан хэрэгждэг ч асуудал биш.

Ерөнхийлөгч өөрөө Монголын талаар сонирхон анхаарч байсан нь айлчлал хэрэгжих үндэс болсон юм. Монголд хийх төрийн айлчлалыг эцэслэн шийдвэрлэхэд янз бүрийн асуудал тулгарч байв.

ОХУ-ын дотоод байдалтай холбогдуулан айлчлалын талаар сөрөг санал ч нилээд гарч байв. Элчин сайдын хувьд би айлчлалыг хэрэгжүүлэхийн хувьд саналтай байж Элчин сайд нарын зөвлөлгөөнд оролцож байх үедээ холбогдох албаны хүмүүстэй уулзан айлчлалын ач холбогдлын талаар тайлбарлаж байв.

Гуравхан дипломат ажилтантай бичил ЭСЯ байж төрийн тэргүүний айлчлалын том арга хэмжээг хэрэгжүүлэх гэж байснаа өнгөрсөн хойно нь бодохоор нуруу руу хүйт оргих шиг. Эцсийн бүлэгт ногоон гэрэл асч Ерөнхийлөгч Ким Дэ Жүний Монголд хийсэн төрийн айлчлалын бэлтгэл бэрхшээлтэй ч гэсэн урагштай явагдаж, айлчлал амжилттай болж энэ айлчлалаар Солонгос, Монголын харилцааг 21 дүгээр зуунд шинэ шатанд өргөжүүлэн хөгжүүлэх үндсийг тавилгаа гэсэн дүгнэлт гарсан билээ.

Дараахан нь 7 дугаар сарын сүүлчээр Үндэсний Ассамблейн дарга Пак Жүн Гю албан ёсны айлчлал хийв. Ерөнхийлөгч Ким Дэ Жүн Монголд айлчилсны дараа ЗХА-ийн гол орны төр, засгийн тэргүүн нар дараалан айлчиллаа, сайн мөртэй хүн юм гэсэн Монголын төр, засгийн удирдлагын талархлын үгийг сонсож байхад Элчин сайдын хувьд бахархалтай, сэтгэл ханамжтай байв. Нэг сонирхолтой зүйл гэвэл адилхан цаг үед төр, засгийн тэргүүн нараа айлчуулсан Монголд суугаа Япон, Хятадын Элчин сайд нар мөн миний араас эх орондоо бүр мөсөн буцсан билээ.